

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААР

Нэг.Оршил

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд 2020 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн даган мөрдөнө.

Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ нь 30 бүлэг, 287 зүйлтэй.

Хоёр: Хуулийн агуулга

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газар санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно. Энэ тохиолдолд өөрчлөлт оруулж байгаа хууль тус бүрд үзэл баримтлалыг тодорхойлох шаардлагагүй.” гэж заасны дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг боловсруулах дараахь хууль зүйн болон практик шаардлага тулгарсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 34 дүгээр тогтоолын Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баталсантай холбогдуулан хууль хоорондын давхардал, зөрчлийг арилгах үүднээс холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгаснаас гадна Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1-д “Тогтвортой, хариуцлагатай улс төрийн соёлыг төлөвшүүлж, хүчтэй, чадамжтай, хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэх зарчмыг баримтална.” гэж, 5.3-т “Хууль заавал хэрэгждэг, хүн бүрд эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтална.” гэж, 5.1.3-т “Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрд батлагдан хэрэгжиж буй бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлнэ.” гэж, 5.2.11-д “Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах...” гэж, 5.4.1-д “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ.” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлаас шинээр аливаа хууль хэлэлцэн батлах бүрт тухайн хуулиар зохицуулсан хориглосон, үүрэг болгосон хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг шинээр зөрчилд тооцон Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид тусгах эсэх асуудлыг тухай бүрт шийдвэрлэх хэрэгцээ шаардлага үүсэх бөгөөд зарим тохиолдолд үүнтэй уялдуулан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах, Эрүүгийн хууль тогтоомжийг практикт хэрэгжихүйц байх нөхцөлийг хангах шаардлага тулгарсан.

Тухайлбал: гэмт хэрэг, зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох зохицуулалтыг уялдуулах, зарим зөрчилтэй уялдуулан гэмт хэргийн шинжийг өөрчлөн найруулах хэрэгцээ, шаардлага үүссэн.

Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад мал хулгайлах гэмт хэргийг өмчлөх эрхийн эсрэг бусад төрлийн гэмт хэрэгтэй адилтган үзэж, ижил хэлбэрийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан бол 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан шинэчилсэн найруулгад бусдын малыг хулгайлан иргэн, аж ахуйн нэгж,

байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулах гэмт хэргийг “Хулгайлах” гэмт хэргээс ялган ойлгож, “Мал хулгайлах” 17.12 дугаар зүйлийг шинээр нэмсэн. 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар уг зүйлд өөрчлөлт оруулсан.

Гэмт хэрэг үйлдэгчдийн ашиглаж буй бага оврын тээврийн хэрэгсэлд дөрвөөс илүү бод мал ачих боломжгүй байдаг. Гэвч хохирлын хэмжээ 17.12 дугаар зүйлийн 2 дахь тайлбарт заасан хэмжээ буюу хорин дөрвөн бог, эсвэл найман бодод хүрээгүй тохиолдолд хүндрүүлж үзэх нөхцөл байдлаар ял шийтгэх боломжгүй, түүнчлэн мал хулгайлах гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүн санаатай нэгдэж, урьдчилан үгсэн тохиролцон бүлэглэж үйлдсэн бол хүндрүүлж үзэх заалтыг хуульд нэмж тусгах шаардлага үүссэн.

Дээрх практик болон эрх зүйн үндэслэл, шаардлагын үүднээс 17.12 дугаар зүйлийн 2 дугаар тайлбар дахь “олон тооны мал”-ын шалгуур тоон үзүүлэлтийг зохистой хэмжээнд хүртэл бууруулан тогтоож, хохирогчид учирсан хохирлыг бодитоор тооцон гэмт хэрэг үйлдэгчдэд ял, шийтгэл хүлээлгэх нь зүйд нийцэх юм гэж хууль санаачлагч үзжээ.

Хуулийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар, цөөн тооны мал хулгайлсан этгээдэд оногдуулах ял, шийтгэл нь хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих зэрэг хувилбартай байсан.

Шүүхийн практикаас харахад дээрх зүйлийн дагуу цөөн тооны мал хулгайлсан этгээдэд хорихоос өөр төрлийн буюу нийтэд тустай хөдөлмөр эрхлэх шийтгэл хүлээлгэх нь түгээмэл бөгөөд ялын энэ төрлөөр шийтгэгдсэн гэмт этгээдүүдийн дийлэнх нь малчинд учруулсан хохирлоо нөхөн төлөлгүй, гэм буруугаа хүлээн зөвшөөрөхгүй өнгөрч, малаа алдсан иргэд хохирч үлдсээр байна. Хорихоос өөр төрлийн ял шийтгэж байгаа тохиолдолд Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн дагуу гэмт этгээд ял хөнгөрүүлэх зорилгоор гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хохирол барагдуулах нөхцөл хангагдахгүй байсан байна.

Энэ хуулиар дараах онцлог өөрчлөлт орсон байна. Үүнд:

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалтыг зөрчлийн хугацаа тоолох зохицуулалттай уялдуулж, улмаар зарим гэмт хэрэг хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалтыг боловсронгуй болгохоор өөрчилсөн.

Гэмт хэргийн хохирол, хор уршгийн ойлголтын хуульд уялдаа холбоотой байхаар зохицуулсан.

Эрх хасах, хорих зэрэг зарим ялын хэмжээтэй холбоотой зохицуулалтын зөрчлийг арилгасан.

Аргагүй хамгаалалтын зохицуулалтанд хамрах хүрээг өргөжүүлсэн.

Шүүхийн практикт хуулийг хэрэглэхтэй холбоотой гарч байгаа хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах, үргэлжилсэн гэмт хэргийн зохицуулалтыг практикт нэг мөр хэрэгжихүйц байдлаар нарийвчлан тусгасан.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээг практикт хэрэглэхтэй холбогдуулан зохицуулалтыг боловсронгуй болгосон.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэрэгт оногдуулах ялыг ерөнхий анги болон тусгай ангид заасан бусад ялтай уялдуулах, зарим гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах зэрэг зохицуулалтыг тусгасан. Тухайлбал Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мал хулгайлсан этгээдэд оногдуулах ял шийтгэлээс “нийтэд тустай ажил хийлгэх” хувилбарыг хассан, мал хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлийг илүү тодорхой болгож ялыг ялгамжтай оногдуулах эрх зүйн үндэслэлийг тогтоож өгсөн.

Зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал, биеэ үнэлэхийг зохион байгуулах, бэлгийн дарамт учруулах, гүтгэх, мөрийтэй тоглоом зохион байгуулах зэрэг гэмт

хэргийг хуульчилж гэмт хэргийн шинжийг ерөнхий ангид заасан нэр томъёотой нийцүүлсэн.

Иймд тус хуульд **цагдаа, дотоодын цэргийн байгууллага**, алба хаагчтай холбоотой хэрэгжүүлэх зүйл, заалт, нэмэлт өөрчлөлтийг харьцуулан түүвэрлэн энэхүү мэдээллийг боловсруулав.

Хуулийг <https://www.legalinfo.mn/law/details/11634> холбоосоор орж дэлгэрэнгүй үзнэ үү.

ГУРАВ.ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТААС

ЕРӨНХИЙ АНГИ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.10 дугаар зүйл. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
-	1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш дараах хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол яллагдагчаар татаж болохгүй: 1.5.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн. <i>/Шинээр нэмсэн/</i>
2.Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж хүртэл тоолно. Яллагдагч, шүүгдэгч өргөн зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг өргөн зайлсан өдрөөс зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно. <i>/Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан байсан/</i>	2.Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно.
-	5.Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байна. <i>/Шинээр нэмсэн/</i>
-	6.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно. <i>/Шинээр нэмсэн/</i>
<p>2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр мөрдөн байцаалтын шатанд прокурорын тогтоолоор болон шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэг /Авлигын гэмт хэрэг/-т заасан гэмт хэргийг сэргээн шалгана.</p> <p>Одоо мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан хууль буцаан хэрэглэх зохицуулалт үйлчлэхгүй.</p>	

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГ

2.5 дугаар зүйл Гэмт хэргийн хохирол, хор уршиг

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
3.Энэ хуульд заасан “ноцтой хохирол” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсныг ойлгоно.	3.Энэ хуульд заасан “ноцтой хохирол, хор уршиг ” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно.
<i>Гэмт хэргийн хохирол, хор уршигийн ойлголтыг уялдаа холбоотой байхаар зохицуулсан.</i>	

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ГЭМТ ХЭРГИЙГ ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ БАЙДАЛ**

4.1 дүгээр зүйл. Аргагүй хамгаалалт

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
1.Өөрийн, <u>ойр дотны хүний</u> амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.	1.Өөрийн, эсхүл бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.
Тайлбар: -Энэ хуульд заасан “ойр дотны хүн” гэж тухайн хүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү, хамт амьдарч байгаа бусад төрөл, садангийн хүнийг ойлгоно.	<i>Хучингүй болсонд тооцсон.</i>
<i>Зөвхөн өөрийн болон ойр дотны хүнд чиглэсэн довтолгооны эсрэг гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж зогсоосон бол аргагүй хамгаалалтад тооцдог байсныг өөрийн болон бусад хүнд /ойр дотны болон хамааралгүй хүн хэн ч байж болох/ чиглэсэн довтолгооны эсрэг гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийж аргагүй хамгаалалт хийсэн үйлдлийг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцохоор хамрах хүрээг өргөжүүлсэн.</i>	

**ТАВДУГААР БҮЛЭГ
ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГЫН ЗОРИЛГО, ТӨРӨЛ**

5.1 дүгээр зүйл. Эрүүгийн хариуцлагын зорилго

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
3.Гэмт хэрэг үйлдэх үед эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн ба хэрэг хариуцах чадвартай хүнд энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу ял оногдуулна.	3.Гэмт хэрэг үйлдэх үед эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн ба хэрэг хариуцах чадвартай хүнд энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

5.4 дүгээр зүйл. Нийтэд тустай ажил хийлгэх ял

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт дөрвөөс дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно.	2.Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ
ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ, ЧӨЛӨӨЛӨХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ**

6.6 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
-	Тайлбар: -Энэ хуульд заасан “ойр дотны хүн” гэж тухайн хүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү, хамт амьдарч байгаа бусад төрөл, садангийн хүнийг ойлгоно. /Шинээр нэмсэн/

6.7 дугаар зүйл. Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
5. Шүүх хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн хүний хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан хохирол нөхөн төлөх хугацааг тэнссэн хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно.	Хүчингүй болсон тооцсон.

6.9 дүгээр зүйл. Хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
1. Ялтан оногдуулсан ялыг эдэлж дуусахаас өмнө шинээр гэмт хэрэг үйлдсэн бол тухайн гэмт хэрэгт нь ял оногдуулж, өмнөх шийтгэх тогтоолоор оногдуулсан ялаас эдлээгүй үлдсэн ялыг нэмж нэгтгэн нийт эдлэх ялын хэмжээг тогтооно.	1. Ялтан оногдуулсан ялыг эдэлж дуусахаас өмнө шинээр гэмт хэрэг үйлдсэн, эсхүл шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа тогтоогдсон бол тухайн гэмт хэрэгт нь ял оногдуулж, өмнөх шийтгэх тогтоолоор оногдуулсан ялаас эдлээгүй үлдсэн ялыг нэмж нэгтгэн нийт эдлэх ялын хэмжээг тогтооно.

6.13 дугаар зүйл. Хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ялаас өвчний учир чөлөөлөх

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
3. Хорих, зорчих эрхийг хязгаарлах ял эдэлж байх үедээ өөрийн эрүүл мэндэд санаатай хохирол учруулсан хүнийг ялаас чөлөөлөхгүй.	3. Хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлж байх үедээ өөрийн эрүүл мэндэд санаатай хохирол учруулсан хүнийг ялаас чөлөөлөхгүй.

**ДОЛДУГААР БҮЛЭГ
ТЭНСЭХ, АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХ**

7.1 дүгээр зүйл. Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
3. Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.	3. Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтооно.

7.4 дүгээр зүйл. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
9. Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно.	9. Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, согтуурах, мансуурах донтой байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно.

**НАЙМДУГААР БҮЛЭГ
ӨСВӨР НАСНЫ ХҮНД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ**

8.1 дүгээр зүйл. Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэн үндэслэл

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийн зохицуулалт
-	6. Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүн шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван найман

	насанд хүрсэн бол энэ хуулийн 8.6 дугаар зүйл хамаарахгүй. /Шинээр нэмсэн/
--	-----------------------------------------------------------------------------------

ТУСГАЙ АНГИ

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

11.2 дугаар зүйл. Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
1.Өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, нэр төр, алдар хүндийг нь гутаан доромжилсон, эрхшээл дарамтад оруулсан хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж сэтгэцийн хэвийн байдал алдагдсаны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, нэр төр, алдар хүндийг нь гутаан доромжилсон, эрхшээл дарамтад оруулсан хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж сэтгэцийн хэвийн байдал алдагдсаны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох , эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

11.3 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
1.Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл бусад болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол нэг жил хүртэл хугацаагаар эрх хасаж зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл бусад болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох , эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

11.4 дүгээр зүйл. Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
2.3.Бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж үйлдсэн бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2.3.Бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж үйлдсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох , эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

11.6 дугаар зүйл. Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
1.Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх	1.Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний

хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

**АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ
ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**

12.1 дүгээр зүйл. Хүчиндэх

<i>2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт</i>
2.10. хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2.10. хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	3. Энэ гэмт хэргийн улмаас ураг зулбасан, эсхүл арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

12.2 дугаар зүйл. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах

<i>2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт</i>
1. Хохирогчийн зөвшөөрлөөр бэлгийн харьцаанд орох үедээ хохирогчийн хүсэл зорилгын эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, тохуурхан доромжилж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1. Хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан нь хүчиндэх гэмт хэргийн шинжгүй бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
-	2. Энэ гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>
-	3. Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>
-	Тайлбар: -Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн хохирогч нь аль ч хүйсийн хүн байж болно. <i>/Шинээр нэмсэн/</i>

12.6 дугаар зүйл. Биеэ үнэлэхийг зохион байгуулах

<i>2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зохицуулалт</i>
6.18 Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих	1. Бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
7. Өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. <i>/Энэ хэсэг хүчингүй болсон./</i>	2. Биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд нь тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлээр хангасан бол нэг жилээс таван жил хүртэл

	хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>
	3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>
	Тайлбар: -Энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол энэ хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарна. <i>/Шинээр нэмсэн/</i>

**АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХҮНИЙ ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**

13.5 дугаар зүйл.Заналхийлэх

<i>2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт</i>
2.2.Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2.2.Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

13.8 дугаар зүйл.Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах

<i>2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт</i>
1.Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх орчны гэрэл зураг авсан , дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, эсхүл бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	1.Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх орчны гэрэл зураг авч, эсхүл дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, эсхүл бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
4.Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг олон нийтэд тараасан нь мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн шинжгүй бол нэг жил хүртэл хугацаагаар эрх хасаж зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	4.Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг олон нийтэд тараасан нь мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн шинжгүй бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

13.10 дугаар зүйл.Хувь хүний нууцад халдах

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
1. Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	1. Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

13.11 дүгээр зүйл.Хувь хүний нууцыг задруулах

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
1. Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	1. Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг хувь хүний, ажил хэргийн, худалдаа, арилжааны нууцыг ажил үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн эмнэлгийн мэргэжилтэн, сурган хүмүүжүүлэгч, хуульч, хууль сахиулагч, нотариатч, нийгмийн ажилтан, төрийн албан хаагч, сэтгэл зүйч, эвлэрүүлэн зуучлагч, банкны ажилтан, аудитор үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2. Албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

13.14 дүгээр зүйл.Худал мэдээлэл тараах

2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зохицуулалт
6.21 Гүтгэх 1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан дөрөмжилсэн худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. /Энэ зүйл хүчингүй болсон./	1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. /Шинээр нэмсэн/
Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйл/Гүтгэх/-д заасан зөрчлийг Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл/Худал мэдээлэл тараах/-д заасан гэмт хэрэгт тооцсон.	

**АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**

15.1 дүгээр зүйл.Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн
-------------------------------------	------------------------------------------------

<i>баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зохицуулалт</i>
1.Эмнэлгийн мэргэжилтэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүйгээс, эсхүл зохих ёсоор биелүүлээгүйгээс хохирогчийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол нэг жил хүртэл хугацаагаар эрх хасаж дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	1.Эмнэлгийн мэргэжилтэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүйгээс, эсхүл зохих ёсоор биелүүлээгүйгээс хохирогчийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

16.1 дүгээр зүйл.Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах

<i>2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зохицуулалт</i>
1.Хүүхдэд амлалт өгч, хууран мэхэлж; хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1. Арван найман насанд хүрсэн хүн хүүхдэд амлалт өгч, хууран мэхэлж; хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2.Хүүхдийг зохион байгуулалттай гэмт бүлэгт, найман жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2. Арван найман насанд хүрсэн хүн хүүхдийг зохион байгуулалттай гэмт бүлэгт, найман жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

17.12 дугаар зүйл.Мал хулгайлах

<i>2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт</i>
1.Бусдын малыг хулгайлсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Бусдын малыг хулгайлсан бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2.Бусдын олон тооны малыг хулгайлсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2.Энэ гэмт хэргийг: 2.1.олон тооны мал хулгайлж; 2.2.бүлэглэж; 2.3.улсын хилээр нэвтрүүлж; 2.4.машин механизм ашиглаж; 2.5.ноцтой хохирол, хор уршиг учруулж; 2.6.гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3.Энэ гэмт хэргийг:	3.Энэ гэмт хэргийг:

3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Тайлбар: -Энэ зүйлд заасан “мал” гэдэгт хонь, ямаа, адуу, үхэр, тэмээ хамаарна. -Энэ зүйлд заасан “олон тооны мал” гэж хорин дөрвөн бог, найман бод , түүнээс дээш малыг ойлгоно. Богийг бодод шилжүүлэхдээ нэг бодыг гурван богоор тооцно.	Тайлбар: -Энэ зүйлд заасан “мал” гэдэгт хонь, ямаа, адуу, үхэр, тэмээ хамаарна. -Энэ зүйлд заасан “олон тооны мал” гэж найман бог, хоёр бод , түүнээс дээш малыг ойлгоно. Богийг бодод шилжүүлэхдээ нэг бодыг дөрвөн богоор тооцно.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ ЭДИЙН ЗАСГИЙН ГЭМТ ХЭРЭГ

18.5 дугаар зүйл. Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан Эрүүгийн хууль
1. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хориглосон, хязгаарлалт тогтоосон барааг Монгол Улсын хилээр, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	1.Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хориглосон бараа, эрдэнэс, эрдсийг Монгол Улсын хилээр, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
3.Энэ гэмт хэргийг түүх, соёлын дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	3.Энэ гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
<i>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн үйлдлийг энэ хуулийн 20.7 дугаар зүйл /Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/-ийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгосон тул энэ хэсгээс хассан.</i>	
-	Тайлбар: -Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн хүнийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлсэн хүнийг ялаас чөлөөлнө. Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн барааг хяналт шалгалтын үеэр, эсхүл мөрдөн шалгах ажиллагааны үед гаргуулан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй. /Шинээр нэмсэн/

18.18 дугаар зүйл. Үндэсний төлбөрийн системийн зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг хууль бусаар эрхлэх

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
1.Үндэсний төлбөрийн системд холбогдох үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын	1.Үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ

зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар эрхэлсэн бол нэг жилээс хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	үзүүлэгчийн, эсхүл төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хасаж зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2.Энэ гэмт хэргийг үйлдэж бусдад гурван зуун сая төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан бол таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2.Үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн, эсхүл төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг хуурч, эсхүл хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсны улмаас бусдын эд хөрөнгө, эдийн болон эдийн бус хөрөнгийн эрхэд ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
-	18.18.3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэж бусдад гурван зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирол учруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>
-	18.18.4.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>
-	18.18.5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>

**АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**

19.12 дугаар зүйл.Төрийн нууцыг задруулах

<i>2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт</i>
1.Төрийн нууцыг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах гэмт хэргийн шинжгүй бол гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Төрийн маш нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах гэмт хэргийн шинжгүй бол гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2.энэ гэмт хэргийг үйлдэж төрийн маш нууц, онц чухал-маш нууцыг задруулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2.Энэ гэмт хэргийг үйлдэж төрийн онц чухал маш нууцыг задруулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

19.13 дугаар зүйл.Төрийн нууцыг үрэгдүүлэх

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зохицуулалт
1.Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд тэдгээртэй харьцах талаар тогтоосон журам зөрчсөний улмаас үрэгдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Төрийн маш нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд тэдгээртэй харьцах талаар тогтоосон журам зөрчсөний улмаас үрэгдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2.Энэ гэмт хэргийн улмаас төрийн онц чухал- маш нууцыг үрэгдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2.Энэ гэмт хэргийн улмаас төрийн онц чухал нууцыг үрэгдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХОРЬДУГААР БҮЛЭГ

ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АШИГ СОНИРХЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

20.7 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зохицуулалт
1.Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Хориглосон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, бусдад өгсөн, олж авсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3.2.улсын хилээр нэвтрүүлж; /Энэ заалтыг 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болгосон байсан/	3.3.улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. /Өөрчлөн найруулсан/
-	4.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ. /Шинээр нэмсэн/
4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

20.12 дугаар зүйл.Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх

2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зохицуулалт
1.Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хүний эрүүл мэндэд хохирол учруулж болох хүнсний, эсхүл хүнсний нэмэлт бүтээгдэхүүн зориуд	1.Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хүний эрүүл мэндэд хохирол учруулж болох хүнсний, эсхүл хүнсний нэмэлт бүтээгдэхүүн зориуд

худалдсан, түгээсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	худалдсан, түгээснээс хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан, эсхүл үлэмж хэмжээний хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

20.17 дугаар зүйл Мөрийтэй тоглоом зохион байгуулах

<i>2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Зөрчлийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зохицуулалт</i>
5.7 дугаар зүйл.Мөрийтэй тоглоом зохион байгуулах	1.Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>
1.Олон нийтийн газар ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом тоглосон бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	2.Үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. <i>/Энэ хэсгийг хүчингүй болгосон./</i>
2. Үрд дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. <i>/Шинээр нэмсэн/</i>	
<i>Зөрчлийн тухай хуулийн 5.7 дугаар зүйл/Мөрийтэй тоглоом зохион байгуулах/-д заасан зөрчлийг Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйл/ Мөрийтэй тоглоом зохион байгуулах/-д заасан гэмт хэрэгт тооцсон.</i>	

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ХЭРЭГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

21.1 дүгээр зүйл.Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах

<i>2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт</i>
1.Хэрэг шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг зөриуд устгасан, нуусан, засварласан, өөрчилсөн, хуурамчаар үйлдсэн, эсхүл нотлох баримтыг хуурамч болохыг мэдсээр байж хууль сахиулагчид, прокурорт, шүүхэд гаргаж өгсөн бол нэг жил хүртэл хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Хэрэг шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг устгасан, нуусан, засварласан, өөрчилсөн, хуурамчаар үйлдсэн, эсхүл нотлох баримтыг хуурамч болохыг мэдсээр байж хууль сахиулагчид, прокурорт, шүүхэд гаргаж өгсөн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

21.2 дугаар зүйл.Худал мэдүүлэх

<i>2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт</i>
-------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------

1.Гэрч, хохирогч мөрдөн шалгах ажиллагааны үед, шүүхэд үнэн зөв мэдүүлэг өгөхөө илэрхийлж, баталгаа гаргасны дараа зориуд худал мэдүүлэг өгсөн бол гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	1.Гэрч, хохирогч мөрдөн шалгах ажиллагааны үед, шүүхэд үнэн зөв мэдүүлэг өгөхөө илэрхийлж, баталгаа гаргасны дараа зориуд худал мэдүүлэг өгсөн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

21.5 дугаар зүйл.Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх

2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
1.Гэрч, хохирогчийг зориуд худал мэдүүлэг өгүүлэх, шинжээчээр худал дүгнэлт гаргуулах, орчуулагчаар худал орчуулуулах, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлэх зорилгоор өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хохирол учруулахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан, шан харамж амласан, өгсөн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	1.Гэрч, хохирогчийг зориуд худал мэдүүлэг өгүүлэх, шинжээчээр худал дүгнэлт гаргуулах, орчуулагчаар худал орчуулуулах, хэлмэрчээр худал хэлмэрчлүүлэх зорилгоор өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хохирол, хор уршиг учруулахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан, шан харамж амласан, өгсөн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

21.10 дугаар зүйл.Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
2.Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг хадгалах, хамгаалах үүрэг бүхий албан тушаалтан завшсан бол нийтийн албанд ажиллах эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2.Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг хадгалах, хамгаалах үүрэг бүхий албан тушаалтан завшсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

21.13 дүгээр зүйл.Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомж зөрчих

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
-	2.Гүйцэтгэх ажил явуулах эрхгүй этгээд гүйцэтгэх ажил явуулсан, эсхүл гүйцэтгэх ажлын тусгай техник олж авсан, ашигласан, борлуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй эмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. /Шинээр нэмсэн/

**ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ
АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ**

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
-	<p>Тайлбар:</p> <p>-Энэ хуульд заасан “албан тушаалын байдал” гэдэгт эрх нөлөө хамаарна.</p> <p>-Энэ хуульд заасан “урвуулан ашиглах” гэж албан үүрэг, албан тушаал, албан тушаалын байдлын эрх мэдлээ албаны эрх ашгийн эсрэг, эсхүл хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийх, эрх мэдлээ хэтрүүлэхийг ойлгоно.</p> <p align="right">/Шинээр нэмсэн/</p>

**ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**

24.2 дугаар зүйл.Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
<p>1.Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар дээр барилга байгууламж барьж хууль бусаар газрын хэвлийд халдсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>1.Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар хууль бусаар газрын хэвлийд халдсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
<p>2.Тусгай зөвшөөрөлтэйгээр ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолт, боловсруулалт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүйн улмаас байгаль орчинд ноцтой хохирол учирсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>2.Тусгай зөвшөөрөлтэйгээр ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолт, боловсруулалт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүйн улмаас байгаль орчинд их хэмжээний хохирол учирсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>

24.3 дугаар зүйл.Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт	2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт
<p>1.Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлсэн, үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, авсан, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, зориулалтын бусаар ашигласан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>1.Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар ашиглан үйл ажиллагаа явуулсан, улсын хилээр нэвтрүүлсэн, үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, авсан, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, зориулалтын бусаар ашигласан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>

24.5 дугаар зүйл.Хууль бусаар ан агнах

<i>2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт</i>
2.Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	2.Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, нэн ховор амьтны чихмэл, түүхий эд, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**ХОРИН ДОЛДУГААР БҮЛЭГ
ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ**

27.7 дугаар зүйл.Агаарын хөдөлгөөний аюулгүй байдалд халдах

<i>2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр баталсан хуулийн зохицуулалт</i>	<i>2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлт</i>
1.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зөвшөөрөлгүй арилжааны нислэг үйлдсэн, заасан маршрутыг зөрчиж ниссэн, агаарын зам, буух газрыг дур мэдэн өөрчилсөн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	1.Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зөвшөөрөлгүй арилжааны нислэг үйлдсэн, заасан маршрутыг зөрчиж ниссэн, агаарын зам, буух газрыг дур мэдэн өөрчилсөн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.